



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯТЫН ГАЗАР**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭС



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН НЭГДСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024 он

Агуулга

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго	2
Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй	2
Гурав. Товч танилцуулга	2
Дөрөв. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үнэлгээ	4
4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	4
Тав. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үнэлгээ	4
Алсын хараа-2050	4
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5
Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	6
Зургаа. Байгууллагын 2024 оны үйл ажиллагаа, чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	6
6.1. Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлт	6
6.2. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	8
6.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	10
6.3.1. Сургалтын арга хэмжээ	11
6.3.2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ	12
Долоо. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	13
7.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	13
7.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	14
7.3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	15
7.4. Хэрэглэгчийн үнэлгээ	17
Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж	17
Ес. Хавсралтууд	18
9.1. Салбарын стратеги төлөвлөгөөний биелэлт	18
9.2. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	18
9.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан (журмын 4 дүгээр хавсралт)	18
9.4. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлт (журмын 9 дүгээр хавсралт), хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	18
9.4. Байгууллагын дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны тайлан	18

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь тус газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Холбогдох бодлогын баримт бичиг, эрх зүйн акт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, агентлагийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206, 217 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж өгч ажиллалаа.


ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг буюу Алсын хараа 2050, Монгол Улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөр, байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлт болон байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайланд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206, 217 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу 3 багц, 11 үзүүлэлтээр дүгнэв.

2024 онд төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн биелэлт, үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээгээр 94.3 хувь буюу 4.71 оноотой үнэлэгдлээ. Тус газар нь 2023 онд 95.8 хувь, 4.79 оноотой үнэлэгдсэн бол 2024 онд буюу 0.08 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны үйл ажиллагааны үнэлгээг хүснэгтээр харуулбал:



Хүснэгт 1.

1	Үзүүлэлт	Хувь	Жин	Оноо
1	2	3		5
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	98.2	0.6	4.71 (-0.08)
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Алсын хараа-2050	100		
	2.Монгол Улсын хөгжлийн жилийн үндсэн чиглэл		0.2	
	3.Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
Байгууллагын 2024 оны үйл ажиллагаа	1. Салбарын стратеги төлөвлөгөөний биелэлт	96.6	0.2	
	2.Байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлт	93.9		
	3.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	95.9		
	4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	90		
	5.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100		
	6.Шударга байдлын түвшний үнэлгээ	80.0		
	7.Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ		94.3	1.0	

ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нийт 5 хууль, Улсын Их Хурлын тогтоол 1, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 7, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс 4, нийт 19 шийдвэрийн 67 зүйл заалтыг хэрэгжүүлэн ажилласныг хяналтад авав. (Хүснэгт 2.)

Дээрх 19 шийдвэр нь бүгд “үр дүн гарсан” буюу 100 хувьтай 59 зүйл, заалт, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн гүйцэтгэлтэй, 6 зүйл, заалт, 70 хувийн гүйцэтгэлтэй 2 зүйл, заалт нийлбэр үнэлгээгээр 98.2 хувь үнэлэгдлээ.

Хүснэгт 2.

Бүгд		Шийдвэрийн төрөл					
		Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан хууль, тогтоол шийдвэрийн тоо	19	5	1	2	7	4	
Заалтын тоо	67	50	1	3	8	5	
ҮНЭЛГЭЭ	Биелсэн (100%)	59	50	-	1	5	3
	Хэрэгжих шатанд (70%)	8	-	1	2	3	2
	Хэрэгжилт хангалтгүй (30%)	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	-	-	-	-	-	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт нь 2024 оны жилийн эцсийн байдлаар дээрх 67 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 98.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 4.9 оноотой үнэлэгдсэн нь эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 0.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ТАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

5.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 онд 1 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь 100 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

“Монгол Улсын удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ” зорилтын хүрээнд хэрэгжилтийн хувийг эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулбал мөн адил 11.1 хувиар үнэлгээ өссөн үзүүлэлттэй байна. (хүснэгт 3)

Хүснэгт 3.

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Дундаж хувь	Оноо	Дундаж хувь	Оноо
				2024 оны эхний хагас жил		2024 оны жилийн эцэс	
1. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого							
1	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	90%	4.5	100%	5

5.2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн арга хэмжээний 2024 оны хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 3 арга хэмжээний хэрэгжилт бүгд 100 хувьтай үнэлэгдсэн байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4.

№	Зорилго, зорилт	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэг жилт /хувь/
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	2.7.3. гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.	1	1	-	-	-	-	-	100
2	7.2.4. гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	1	1	-	-	-	-	-	100
3	7.4.7. Хууль сахиулах байгууллагууд иргэдийн	1	1	-	-	-	-	-	100

	өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.								
4	Нийт	3	3	-	-	-	-	-	100
Оноо		5							

5.3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй буюу 100 хувьтай үнэлэгдсэн нь эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулбал гүйцэтгэлийн хувь 11.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (Хүснэгт 5, 6.)

Хүснэгт 5.

№	Бодлогын чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилт /хувь/
				100%	90%	70%	50%	30%	0%	
1	Засаглалын бодлого	1	1	1	-	-	-	-	-	100
Оноо		5								

Хүснэгт 6.

№	Зорилт, дэс дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Дундаж хувь	Оноо	Дундаж хувь	Оноо
			2024 он эхний хагас жил		2024 он	
4.Засаглалын бодлого						
1	4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно	2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	90%	4.5	100%	5

ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт:

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилтын 23 арга хэмжээг тус тус үнэлгээнд хамруулсан болно.

Нийт арга хэмжээний 15 буюу 65.2% нь үр дүнтэй, 5 буюу 21.7% нь тодорхой үр дүнд хүрсэн, 3 буюу 13% нь эрчимжүүлэх шаардлагатай байна. (График 1, Хүснэгт 7)

График 1.



Хүснэгт 7.

Нийт арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/				Нийт үнэлгээ /хувиар/
	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)		
	100%	90%	50%	30%	
23	15	5	3	-	93.9

Зорилт тус бүрээр ангилан үзвэл хамгийн сайн үнэлэгдсэн “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан 6 арга хэмжээ бүгд үр дүнтэй буюу 100 хувь, “Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх” зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд хамгийн бага буюу 80 хувиар үнэлэгдлээ. (Хүснэгт 8)

Хүснэгт 8.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
			100%	90%	70%	30%	
1	Гадаадын иргэн, харьяатын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх	5	3	2	-	-	96
2	Технологийн дэвшилд тулгуурласан үйл ажиллагааны дэд бүтцийг бий болгох	2	1	1	-	-	95
3	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх	6	6	-	-	-	100
4	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн	2	-	1	1	-	80

	байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх						
5	Шинэчлэлд нийцсэн, тогтвортой, чадварлаг, хариуцлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	4	3	1	-	-	97.5
6	Эрхлэх асуудлын эдийн засаг, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, өргөжүүлэх	4	2	-	2	-	85
Нийт		23	15	5	3	-	92.25

Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 93.9 хувь буюу 4.7 оноогоор үнэлэгдлээ.

6.2. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ төлөвлөснөөс 34 буюу 77.3% нь үр дүнтэй, 7 буюу 15.9% нь тодорхой үр дүнд хүрсэн бол эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хувийн гүйцэтгэлтэй 3 арга хэмжээ нь 6.8% тус тус эзэлж байна. (Хүснэгт 9, График 2.)

Хүснэгт 9.

Нийт арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/				Нийт үнэлгээ /хувиар/
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
	100 хувь	70-100 хүртэл хувь	30-70 хүртэл хувь	0-30 хүртэл хувь	
44	34	7	3	-	95.9

График 2.



Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан ажлууд хамгийн үр дүнтэй буюу 100 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан ажлууд 94.1 хувь, “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан ажлууд 94.2 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 10)

Хүснэгт 10.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
			100 хувь	70-100 хүртэл хувь	30-70 хүртэл хувь	0-30 хүртэл хувь	
1	2	3	4	5	6	8	9
1	Зорилт 1.Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэг, гуравдугаар зорилт)	4	4	-	-	-	100
2	Зорилт 2.Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр зорилт)	9	9	-	-	-	100
3	Зорилт 3. Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги	24	16	6	2	-	94.1

	төлөвлөгөөний дөрөв, тав, зургаадугаар зорилт)						
4	Зорилт 4. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэг, гуравдугаар зорилт)	7	5	1	1	-	94.2
	Нийт	44	34	7	3	-	97.07

Байгууллагын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.9% буюу 4.8 оноотой дүгнэгдлээ. Үүнээс үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн 41 арга хэмжээ буюу нийт арга хэмжээний 93.2 хувийг эзэлж байгаа нь удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан харагдаж байна.

Энэ нь эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 7.1 хувиар өссөн, 2023 оны жилийн эцсийн үнэлгээтэй мөн адил харьцуулбал 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй дүгнэгдлээ.

6.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд нийт 4 зорилтын 49 арга хэмжээ, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэй сургалтын төлөвлөгөөг, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 4 зорилтын 34 арга хэмжээг тус тус төлөвлөн 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгууллагын даргаар батлуулан хэрэгжүүлсэн байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөрийн 41 зорилтын хүрээнд 2024 онд нийт 4 зорилтын 49 арга хэмжээнээс 59.2 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 34.7 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувьтай, 4.1 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувь, үр дүнгүй 1 ажил 2.04 хувийг эзэлж байна. (График 3)

График 3.



Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөрийн биелэлтийг хангах, эрчимжүүлэх хүрээнд байгууллага нь албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын болон төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнүүдийг тус тус батлан хэрэгжүүлснийг дараах байдлаар хяналтад авлаа.

6.3.1. Сургалтын арга хэмжээ:

2024 онд Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын төлөвлөгөөний биелэлт нь 93.3 хувьтай зорилт тус бүрийн дунджаар 86.9 хувьтай тус тус үнэлэгдсэн байна. (Хүснэгт 11)

Хүснэгт 11.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь Дундаж хувь
	Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн 90%	Эрчимжүүлэх шаардлагатай 70%	Үр дүнгүй 50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
30	20	5	5	-	-	-	93.3%

Байгууллагын хувьд 2024 онд сургалтын төлөвлөгөөнд туссан нийт 6 зорилтын 30 арга хэмжээ нь дараах бүтцийн хүрээнд төлөвлөгдсөн байна. Үүнд: Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж, нөхцөлийг хангах -44 хувийг, Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлэх -3 хувийг, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг

хэрэгжүүлэх -3 хувийг, Гадаад сургалт зохион байгуулах -10 хувийг, Хувь хүний хөгжил, ёс зүй, харилцаа хандлагын сургалт зохион байгуулах -13 хувийг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, холбогдох хуулийг сурталчлах -2 хувийг тус тус эзэлж байна. (График 4)

График 4.



6.3.2. Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ:

Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 29 зорилтын биелэлтийг хангах чиглэлээр 2024 онд 4 зорилтын 34 арга хэмжээг төлөвлөснөөс биелэлт 90 хувь, төлөвлөгөөний зорилт тус бүрийн дунджаар 92.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ. (Хүснэгт 12)

Хүснэгт 12.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй 0%	
		90%	70%	50%	30%		Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8
34	18	10	4	1	1	-	90%

Хүснэгт 13.

Д/д	Төлөвлөгөөний зорилт	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	“Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж, нөхцөлийг хангах”	1	1	-	-	-		100
2	“Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлэх”	13	3	7	3	-	-	87.6
3	“Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлэх”	12	9	1	1	-	1	90.8
4	“Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд агентлагийн хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”	8	5	2	-	1	-	91.25
Нийт		34	18	10	4	1	1	92.4

Байгууллагын 2024 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 283.8 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

7.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд 5 зорилт, 46 шалгуур үзүүлэлтээр жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Эдгээр 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 онд бүгд үр дүнтэй буюу 100 хувьтай үнэлэгдсэн байна. (Хүснэгт 14, 15)

Хүснэгт 14.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь Дундаж хувь
	Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн 90%	Эрчимжүүлэх шаардлагатай			Үр дүнгүй 0%	
			70%	50%	30%		
1	2	3	4	5	6	7	8
46	46	-	-	-	-	-	100%

Хүснэгт 15.

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	10	-	-	-	-	100
2	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	6	-	-	-	-	100
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	15	-	-	-	-	100
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	2	-	-	-	-	100
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	13	-	-	-	-	100
Нийт		46	46	-	-	-	-	100

7.2. Байгууллагын шилэн дансны үнэлгээ:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны гуравдугаар улирлын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэлтэй мэдээлэл байршуулах, тайлан илгээх үүрэг бүхий Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч зэрэг нийт хууль

хэрэгжүүлэгч 8 байгууллага нь 3 ангиллын 29 төрлийн 1080 мэдээллийг байршуулахаас 1078 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, олон нийтэд тайлагнасан байна.

Системд бүртгэлтэй байгууллагуудын 2024 оны шилэн дансанд оруулсан мэдээллийн хэрэгжилтийг нэгж тус бүрээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт 16.

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	135	135	-	-	100.0
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	135	135	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	135	135	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	135	134	1	-	99.2
5	Өмнөд бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	135	134	1	-	99.2
7	Зүүн бүс дэх газар	1	135	135	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	135	135	-	-	100.0
Нийт дүн		8	1080	1078	2	-	99.8

2024 оны гуравдугаар улирлын байдлаар төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын холбогдох мэдээллийг цахим хуудсанд байгууллагын хэмжээнд 3 ангиллаар 29 төрлийн 1080 мэдээлэл байршуулахаас 1078 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 99.8 хувийн хэрэгжилттэй “ХАНГАЛТТАЙ” хэмжээнд байна.

7.3. Байгууллагын шударга байдлын үнэлгээ:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7-д заасан үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга

байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу Засгийн газрын агентлагуудын 2022 оны шударга байдлын үнэлгээг хийсэн билээ. Гадаадын иргэн, харьяатын газрын хувьд тухайн онд 80.0 хувьтай нийт 31 агентлагуудаас 13 дугаарт орж улсын дунджаас 8.2 хувиар дээгүүр үнэлэгдсэн байна. (Зураг 1,2.)

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ - 2022

ХАВСРАЛТ 2. 2022 ОНЫ ҮНЭЛГЭЭ



ХАВСРАЛТ 3. ШБҮ, 2021, 2022 ОН

№	Байгууллагын нэр	2021	2022	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ		72.9	73.9	1.0
Яам		72.8	74.4	1.6
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	66.1	71.1	5.0
2	Барилга, хот байгуулалтын яам	73.0	68.0	-5.1
3	Батлан хамгаалах яам	69.5	80.5	10.9
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	72.2	68.4	-3.8
5	Гадаад харилцааны яам	73.7	77.6	3.9
6	Зам, тээврийн хөгжлийн яам	73.6	74.5	0.9
7	Сангийн яам	73.4	75.3	2.0
8	Соёлын яам	77.8	79.5	1.7
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	72.4	71.2	-1.1
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	75.6	76.0	0.4
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	70.9	71.5	0.5
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	72.1	78.8	6.7
13	Эрүүд мэндийн яам	68.2	65.2	-3.0
14	Эрчим хүчний яам	79.9	78.7	-1.2
15	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	0.0	75.2	-
16	Эдийн засаг, хөгжлийн яам	0.0	79.4	-
Агентлаг		73.9	75.6	1.7
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	79.5	76.5	-3.0
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	71.5	68.1	-3.4
19	Онцгой байдлын ерөнхий газар	69.4	78.9	9.5
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	79.2	78.2	-1.1
21	Стандарт, хэмжил зүйн газар	77.1	79.3	2.2
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	74.8	72.8	-2.0
23	Гаалийн ерөнхий газар	68.2	65.8	-2.4
24	Татварын ерөнхий газар	70.4	72.6	2.2
25	Цагдаагийн ерөнхий газар	73.4	73.6	0.2
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	67.3	72.2	4.9
27	Архивын ерөнхий газар	76.9	79.6	2.7
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	75.7	72.1	-3.6
29	Гадаадын иргэн, харьяатын газар	76.8	80.0	3.2

Мэдээллийн эх сурвалж: Авлигатай тэмцэх газар

7.4.Хэрэглэгчийн үнэлгээ:

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээг “Эс Ай Си Эй” ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/08-19 дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр гэрээлэн гүйцэтгүүлсэн.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийж, дүнг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалаар тооцож үнэлэхэд ерөнхий үнэлгээ 94.3 хувь, 4.71 оноотой дүгнэгдсэн нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 0.08 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

Иймд зохион байгуулалтын нэгжүүд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөлт, шалгуур үзүүлэлтэд анхаарч “тодорхой үр дүнд хүрсэн” хэдий ч бүрэн хэрэгжээгүй, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээг байгууллагын 2025 оны холбогдох төлөвлөгөөнд тусган үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, биелэлтийг бүрэн хангаж, үр дүнтэй ажиллах шаардлагатай.

--oo0oo--